



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 374,110,776.92 (гурван зуун далан дөрвөн сая нэг зуун арван мянга долоон зуун далан зургаан төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1.Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг болох техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг заалт бүрээр ханганд ажиллах, төлөвлөлтийг сайжруулах;

2.2.Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3.“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Р.Дагдан)-д Төрийн өмчийг эзэмшиүүлэх гэрээний 4.2. дахь заалтыг ханганд ажиллаж, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханганд ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. “Абая хараат уул” ХХК-д илүү шилжүүлсэн мах, махан бүтээгдэхүүний үнэ болох 13,010,776.92 (арван гурван сая арван мянга долоон зуун далан зургаан төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, компанийг хохиролгүй болгох;

3.3. Захиалагчийн албаны зардал, магадалшгүй ажлын зардлыг тухайн ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгоогүйгээс илүү төлсөн 21,200,000 (хорин нэгэн сая хоёр зуун мянган) төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, компанийг хохиролгүй болгох;

3.4. Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, бусдын эзэмшил газар дээр байрладаг КТП, ХТП, АТП-ын барилга, байгууламжуудад хамаарах эзэмшил газрын судалгааг гаргаж компанийн нэр дээр шилжүүлэн баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

3.5. Компанийн нэр дээр бүртгэлтэй, 8 нэгж талбарын 9,007.58 м.кв газрын эзэмших эрхийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх;

3.6. Төрийн болон орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг, тооллогын баримтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг газарт 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлэх;

3.7. Их засвар, хөрөнгө оруулалт, техник, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үндсэн хөрөнгө бэлтгэх, төлөвлөгөөний хөдлөл өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн зөвшөөрөл авч байх;

3.8. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д заасан "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;"-ийг хориглоно гэснийг хэрэгжүүлж ажиллах;

3.10. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах;

3.11. Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасан дотоод аудитын үйл ажиллагаанд эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөл, нягтлан бodoх бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд хяналт тавихаар заасан чиглэлийн дагуух ажлыг эрчимжүүлэх;

3.12. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

В.Түвшинзаяа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 03 дугаар сарын ~~03~~-ны
өдрийн ~~103~~ дугаар тогтоолын хавсралт

**“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИД ХИЙСЭН БАРИМТЫН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ,
ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

| Д/д | Зөрчил дутагдлын утга | Мөнгөн дүн /төгрөг/ | Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал |
|--|--|--|---|
| 1 | Санхүүжилт болон барааны үнийг илүү олгосон | 34,210,776.92 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалыг мөрдөж ажиллах. |
| 2 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл арга хэмжээ | 208,500,000 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах. |
| 3 | Зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл олж бэлтгэсэн | 105,000,000 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөж ажиллах. |
| 4 | Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй компаниас худалдан авалт хийсэн | 26,400,000 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах. |
| 5 | 8 нэгж талбар 9,007.58 м.кв газар эзэмших эрхийг үнэлж санхүүгийн тайланда тусгаагүй | - | Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах. |
| Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн: | | 374,110,776.92 (гурван зуун далан дөрвөн сая нэг зуун арван мянга долоон зуун далан зургаан төгрөг ерэн хоёр мөнгө) төгрөг | |